

**УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛГИЙН 2025-2026 ОНЫ
ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН ТАЙЛАН**

№	Төсөл, хөтөлбөрийн нэр	Төсөл, хөтөлбөр хэрэгжих хугацаа	Хэрэгжүүлэх албан тушаалтан, алба, тасаг, нэгж	Гүйцэтгэсэн байдал	Гүйцэтгэсэн хугацаа	Гүйцэтгэлийн хувь
1	KOFIH төсөл	2020-2025	Эмнэлгийн захиргаа, СГХА, KOFIH төслийн багийн гишүүд	УХТЭ-ийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор: 1.Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн УХТЭ дэх ажлын байр болон багц цагийн сургалт 2.Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг Солонгос улсад ажлын байрны сургалтад хамруулах 3.Солонгос улсын зочин профессоруудыг УХТЭ-т урин сургалт, семинар, ажлын байрны сургалтыг зохион байгуулах 4.Шаардлагатай тоног төхөөрөмжийг Солонгос улсын хөрөнгө оруулалттайгаар УХТЭ-т суурилуулах	2020-2025	100
2	Эд эс, эрхтэн шилжүүлэн суулгах	2024-2029	Эд эс, эрхтэн шилжүүлэн суулгах баг, Эмнэлгийн алба, тасаг, алба, нэгжүүд	1. УХТЭ-ийн эд эс, эрхтэн шилжүүлэн суулгах төвийн эмч нарын баг амьд донороос элэг шилжүүлэн суулгах 5 дахь удаагийн дурангийн мэс заслыг амжилттай хийсэн.	2025.03-2025.10	50

				2. Амьд донороос бөөр шилжүүлэн суулгах багийн шишүүд Тайван улс болон УНТЭ-т ажлын байрны сургалтад хамрагдаж байна.		
3	Төрийн байгууллагын төгөлдөршлийн тогтолцоо, Азийн загвар байгууллага төлөвшүүлэх төсөл	2025-2026	Эмнэлгийн захиргаа, ЭМТҮЧАБ, Эмнэлгийн үйл ажиллагааны зохицуулалтын тасаг, Эмнэлзүйн зохицуулалтын алба, Ариутгал халдваргүйтгэлийн тасаг	Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх агентлаг, Бүтээмжийн төв, УХТЭ нь 2025.04.07-ны өдөр гурвалсан гэрээ байгуулан төсөл хэрэгжүүлэх УХТЭ-ийн ажлын хэсэг, холбогдох тушаал, хийх ажлын төлөвлөгөө батлагдсан. Ажлын хэсгийн гишүүд шаардлагатай сургалтад хамрагдан “Өвчний түүх нээх хэсгийн үйл ажиллагааг сайжруулах нь” төслийн одоогийн байдлыг үнэлэх суурь судалгааг хийн, дүнг Бүтээмжийн төвд танилцуулсан. Төсөл 2025.10-2026.10-д хэрэгжих бөгөөд, төслийн үйл ажиллагаа төлөвлөгөөний дагуу явж байна.	2025.04-2025.10	50
4	JCI-аар магадлан итгэмжлэгдсэн эмнэлэг болох	2024-2027	Эмнэлгийн алба, тасаг, алба, нэгжүүд	2025.01 дүгээр сард JCI стандартыг нэвтрүүлэх ажлын албаны гишүүд томилогдон, холбогдох тушаал, ажлын төлөвлөгөө боловсруулагдсан. Ажлын хэсгийн гишүүд JCI стандартын орчуулга хийн эмнэлгийн нийт эмч, эмнэлгийн	2025.01-2025.10	50

				мэргэжилтнүүдэд 2025.01 сараас 2025.03 сар хүртэл сургалт зохион байгуулсан		
5	Ариун цэврийн өрөөг шинэчлэх төсөл	2025.10-2025.12	Эмнэлгийн захиргаа, Эмнэлгийн үйл ажиллагааны зохицуулалтын тасаг	Premium nexus-ийн ЭМЯ-тай байгуулсан санамж бичгийн хүрээнд “Ариун цэврийн өрөөг шинэчлэх төсөл”-д УХТЭ хамтран ажиллахаар сонгогдсон. Төслийн хүрээнд 4 объектын нийтийн хэсгийн ариун цэврийн өрөө 135.892.900 төгрөгийн хөрөнгө оруулалтаар шинчлэгдэнэ. Төслийн ажил төсөлд санал өгөх, гэрээ байгуулах хүрээнд явагдаж байна.	2025.07-2025.10	20
6	Япон улсад туршлага судлах илгээлтийн эзэд	2024.09-2025.09	Эрдэм шижилгээ, инноваци, хөгжлийн бодлого хариуцсан дэд захирал, СГХА	2024.10 дугаар сараас сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтнийг Япон улсад нэг сарын хугацаатай туршлага судлуулах Илгээлтийн эзэд хөтөлбөр хэрэгжсэн. Энэхүү хөтөлбөрт 18 сувилагч, 1 цахим бүртгэлийн ажилтан, 2 эдийн засагч, 1 инженер, 2 угаагч, 1 лаборант, 1 мужаан, 1 цахилгаанчин, 1 сувилахуйн арга зүйч, 1 хүний нөөцийн ажилтан, 2 нярав, 2 тогооч, 2 үйлчлэгч, нийт 35 ажилтан хамрагдсан.		100
7	Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн	2025.01-2025.04	ЭМТҮЧАБ, Эмнэлгийн үйл ажиллагааны	Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын 2025.01.31-ний өдрийн А/06 тоот тушаалын дагуу	2025.01-2025.04	100

	амбулаторийг “Улсын жишиг” болгох төсөл		зохицуулалтын тасаг, ариутгал халдваргүйтгэлийн тасаг	Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн амбулаторийг “Улсын жишиг” болгох төслийн УХТЭ дэх ажлын хэсэг байгуулагдсан. Төслийн төлөвлөгөөний дагуу Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн захиргаа, холбогдох албан тушаалтантай 3 удаагийн онлайн уулзалтыг зохион байгуулж ажлын хэсгийн гишүүд 2025.04.25-04.26-ны өдрүүдэд Баянхонгор аймагт ажилласан.		
8	Монгол Улсад эмчлэгдэх боломжгүй “Титэм судасны хүнд зэргийн нарийслыг эмчлэх” төсөл	2024-2025	Эмнэлгийн захиргаа, СГХА, Зүрх судас судлалын тасаг	ЭМС-ын “Монгол Улсад эмчлэгдэх боломжгүй өвчлөлийг бууруулах” бодлогын хүрээнд дэвшилтэт технологи, арга, аргачлал нэвтрүүлэх, хүний нөөцийг бэлтгэх, сургах, зорилтод ажлын хүрээнд УХТЭ-ийн 5 хүнтэй эмч, эмнэлгийн мэргэжилтний баг “Зүрхний титэм судасны хүнд хэлбэрийн нарийсал, судасны дисплази эмчилгээ”-г Монгол Улсад нутагшуулах зорилгоор БНХАУ-ын Шанхай хотод 2024.07-2024.08 хооронд суралцан ирсэн. УХТЭ-ийн, зүрх судас судлалын тасгийн шигдээсний нэгж хамтран дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн IVUS+NIRS дүрс оношилгооны төхөөрөмжийг	2024.06-2025.06	100

				суурилуулж, ашиглалтад орууллаа.		
9	Эмнэлзүйн практикт тархины эмгэгийн ПЭТ/КТ нэвтрүүлэх.	2024-2026	Эмнэлгийн захиргаа, Цөмийн оношилгоо эмчилгээний төв	Шаардлагатай програм хангамжийг худалдан аван, Цөмийн оношилгоо эмчилгээний төвийн, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд шаардлагатай сургалтад хамрагдсан. Тоног төхөөрөмж худалдан авах шатанд явж байна.	2024.09-2025.09	70
10	Цусны хорт хавдрын өдрийн болон хэвтэн эмчлүүлэх тусламж үйлчилгээг нэвтрүүлэх	2024-2026	Эмнэлгийн захиргаа, Захиргаа хүний нөөцийн алба, СГХА, Цус судлалын эмч	Уян дуран болон Olympus товар бэлэн байгаа. Цаашид цус судлалын эмчийг сургалтад хамруулах	2024-2025	40
11	Ангиографийн ажилбарын үеийн судсан дотуурх эхогоор үнэлэх шинжилгээг УХТЭ-д нэвтрүүлэх	2024-2026	Эмнэлгийн захиргаа, СГХА, Зүрх судас судлалын тасаг	Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд БНХУ-д суралцан, шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авсан. Шинжилгээ УХТЭ-т нутагшсан.	2024-2025	100
12	Трэйнинг центр тохижуулах	2025-2026	Эрдэм шинжилгээ, инноваци, хөгжлийн бодлого хариуцсан дэд захирал, СГХА	АШУҮИС, УХТЭ-ийн хамтын ажиллагааны хүрээнд сургалтын өрөөг шинэчлэх ажил төсвийн төсөөлөл хийх шатанд явж байна.	2025.09 сараас	10
13	Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем хөгжүүлэлт	2025.01-2025.12	Захиргаа хүний нөөцийн алба, Эмнэлгийн үйл ажиллагааны зохицуулалтын тасаг, Мэдээлэл	Эмнэлгийн ажилтан, албан хаагчдын бүртгэлийн нэгдсэн сан үүсгэсэн.	2025.01-2025.12	60

			технологийн алба, СГХА			
--	--	--	---------------------------	--	--	--

ТАЙЛАНГ ГАРГАСАН:

ЭМНЭЛГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИЦУУЛАЛТЫН ТАСГИЙН ЭРХЛЭГЧ,
СУРГАЛТ, ГАДААД ХАРИЛЦААНЫ АЛБАНЫ ДАРГЫГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.МӨНГӨНШҮР